

Сэдэв: Чухал хэсгийг мэдэж сэдвийн хүрээнд ярьж бичиж сурцгаая нэгж хичээлийн үнэлгээ I

Эхийг анхааралтай уншаад,даалгаврыг гүйцэтгээрэй.

Тэнгэрт өлгөөтэй бяслаг

Хулганы гөлчгий хоолоо голж заавал бяслаг иднэ гэж усан нүдэлжээ. Хөөрхий эх нь эрх үрээ аргадаж “Ээж нь одоохон, одоохон” гэсээр бяслагны эрэлд гарчээ. Бэлэн зэлэн бяслаг хаанаас зам дээр хэвтэж байх билээ.Эхийгээ ирэхгүй удаад байхаар нь гөлчгий гэрээсээ гарчихжээ. Намуухан үдшийн одод түгж, жирвэс жирвэс ирмэлцэнэ. Хором хормоор дээшлэх хорьдын тэргэл сарыг эрх гөлчгий анх удаа олж харжээ. Тэгээд “Еэ гялай, еэ гялай. Ямар том бяслаг вэ? Яагаад уулын орой дээр тавьсан юм бол?Ээж минь үүнийг авчрахаар явж дээ. Араас нь очиж ээждээ тусалдаг хэрэг хэмээн уул өөд өгсөж гарлаа.Өлийгөөд харвал өнөөх бяслаг маань тэнгэрт өлгөөтэй байв. Ямар хачин бяслаг вэ?Тавагнаасаа хөөрөөд тэнгэрт гарсан бяслагийг би л лав үзээгүй хэмээн үглэхэд: -Тэнэгхэн гөлчгий минь тэр чинь бяслаг биш сар шүү дээ гээд ээж нь зогсож байлаа.

/О.Сундуй/

1. Хоолоо голж усан нүдэлдэг байжээ.

1. А. бөжин Б. гөлөг В. гөлчгий Г. Бөөдий

2. Үдшийн тэнгэрт түгжээ.

А. манан Б. утаа В. одод Г. Сар

3. Гөлчгийн харсан бяслаг нь өлгөөтэй байв.

А. тэнгэрт Б. өлгүүрт В. ууланд Г. Хаданд

4. Ээж нь : - Бяслаг биш гэв.

А. ааруул б. одод В. нар Г. сар

5. Үгийн утгыг тайлбарлаарай.

Сэлүүн-

Талын шувууд-

6. Зөв холбоорой.



Тогоруу



Ангир



Нугас